DEFENSE RESEARCH INSTITUTE OF MONGOLIA

Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230

Research Article

DOI: https://doi.org/10.65816/jsds.2026.02.009

Theoretical and Methodological Approaches to the Development of an Artificial Intelligence-Driven Cybersecurity Protection Model for the Defense Sector of Mongolia

Chadraabal Baatar

Senior Lecturer, Department of Public Management, National Academy of Governance, Master of Philosophy (M.Phil), E-mail address: baatar@naog.gov.mn, ORCID: 0009-0002-5222-9811

Received: 05 May 2026
Revised: 12 June 2026
Accepted: 30 June 2026
Published online: 28 July 2026

ABSTRACT

In the context of accelerating digital transformation, network-centric operations, and the growing interdependence of information infrastructures, cyberspace has become an integral component of national security and defense systems. Under these conditions, traditional defensive mechanisms alone are no longer sufficient, and the importance of artificial intelligence (AI)-based cybersecurity solutions is rapidly increasing. The purpose of this paper is to define the theoretical and methodological foundations for developing an AI-based cybersecurity model tailored to the specific characteristics of Mongolia's defense sector. The study examines the integration of AI into cybersecurity systems by applying risk management theory, systems theory, information security architecture theory, game theory, and organizational resilience theory. It also investigates the applications of machine learning, deep learning, anomaly detection, malware classification, risk prediction, automated response mechanisms, and cyber intelligence data processing. As a result, a methodological framework for implementing an AI-based cybersecurity model in Mongolia's defense sector is proposed, consisting of key stages such as risk assessment, data collection and processing, machine learning model development, real-time monitoring, and automated response. Furthermore, an architectural model is introduced, comprising a data collection layer, threat intelligence repository, machine learning analytics module, risk assessment module, automated decision-making system, SOAR platform, and strategic management dashboard. This model provides both theoretical and practical significance for enhancing early threat detection, reducing cyber risks, supporting decision-making processes, and strengthening national defense capabilities.

Keywords: *Machine Learning; Anomaly Detection; Risk Assessment; Automated Response; Information Security Architecture; Strategic Decision-Making.*

Монгол Улсын батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлын хиймэл оюунд суурилсан хамгаалалтын загвар боловсруулах онол, арга зүйн асуудал

Чадраабал Баатар

Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн ахлах багш, магистр,
baatar@naog.gov.mn, ORCID: 0009-0002-5222-9811

ХУРААНГУЙ

Дижитал шилжилт, сүлжээ төвтэй ажиллагаа болон мэдээллийн дэд бүтцийн хамаарал өсөн нэмэгдэж буй өнөө үед кибер орчин нь үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж байна. Иймэрхүү уламжлалт хамгаалалтын арга хэрэгслүүд дангаараа хангалттай үр дүн үзүүлэхгүй болсон бөгөөд хиймэл оюунд суурилсан кибер хамгаалалтын шийдлүүдийн ач холбогдол эрчимтэй нэмэгдэж байна. Энэхүү өгүүллийн зорилго нь Монгол Улсын батлан хамгаалах салбарын онцлогт нийцсэн хиймэл оюунд суурилсан кибер хамгаалалтын загвар боловсруулах онол, арга зүйн үндсийг тодорхойлоход оршино. Өгүүлэлд эрсдэлийн удирдлагын онол, системийн онол, мэдээллийн аюулгүй байдлын архитектурын онол, тоглоомын онол болон байгууллагын тогтвортой байдлын онолыг ашиглан хиймэл оюуныг кибер хамгаалалтын тогтолцоонд нэгтгэх боломжийг шинжилсэн. Мөн машин сургалт, гүн сургалт, аномали илрүүлэлт, хортой кодын ангилал, эрсдэлийн урьдчилсан таамаглал, автомат хариу арга хэмжээ болон кибер тагнуулын мэдээлэл боловсруулах чиглэл дэх хэрэглээг судалсан. Судалгааны үр дүнд Монгол Улсын батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэх хиймэл оюунд суурилсан хамгаалалтын загварын арга зүйг эрсдэлийн үнэлгээ, өвөгдөл цуглуулах ба боловсруулах, машин сургалтын загвар хөгжүүлэх, бодит цагийн хяналт, автомат хариу арга хэмжээ гэсэн үндсэн үе шатуудаар тодорхойлсон. Түүнчлэн өвөгдөл цуглуулах давхарга, аюул заналын тагнуулын сан, машин сургалтын аналитик хэсэг, эрсдэлийн үнэлгээний модуль, автомат шийдвэр гаргалтын систем, “Аюулгүй байдлын уялдуулалт, автоматжуулалт ба хариу арга хэмжээ (SOAR)”-ний платформ болон стратегийн удирдлагын самбараас бүрдэх архитектурын загварыг санал болгосон. Энэхүү загвар нь кибер халдлагыг эрт илрүүлэх, эрсдэлийг бууруулах, шийдвэр гаргалтыг дэмжих, үндэсний батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх онолын болон практик ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: *Машин сургалт; Аномали илрүүлэлт; Эрсдэлийн үнэлгээ; Автоматжуулсан хариу арга хэмжээ; Мэдээллийн аюулгүй байдлын архитектур; Стратегийн шийдвэр гаргалт.*

Оршил

Орчин үед батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг хангахад хиймэл оюун нь илрүүлэлт, хамгаалалт, урьдчилсан таамаглал болон хариу арга хэмжээний бүх түвшинд өргөнөөр ашиглагдаж байна. Тодруулбал, хиймэл оюунд суурилсан системүүд нь сүлжээний урсгал, лог файл, хэрэглэгчийн зан төлөв болон төхөөрөмж хоорондын харилцааг бодит цаг хугацаанд шинжилж, хэвийн үйл ажиллагаанаас хазайсан аномали болон сэжигтэй үйлдлийг автоматаар илрүүлэх боломжийг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ машин сургалтын алгоритмууд нь өмнөх халдлагын өгөгдөлд тулгуурлан шинэ төрлийн кибер халдлагын хэв шинжийг таних чадварыг нэмэгдүүлж, уламжлалт гарын үсэгт суурилсан хамгаалалтын аргын сул талыг нөхөж байна. Батлан хамгаалах байгууллагууд хиймэл оюуныг мөн халдлагын эрсдэлийг урьдчилан таамаглахад ашиглаж, эмзэг байдлын магадлал болон довтолгооны чиг хандлагыг тооцоолсноор стратегийн шийдвэр гаргалтыг

сайжруулдаг. Үүнээс гадна хиймэл оюун нь автомат хариу арга хэмжээний системтэй уялдан ажиллаж, илэрсэн аюулыг тусгаарлах, сүлжээний урсгалыг хаах, халдварлагдсан системийг хамгаалах зэрэг үйлдлийг хүний оролцоогүйгээр гүйцэтгэх боломжийг олгодог. Мөн аюул заналын тагнуулын мэдээллийг боловсруулахад байгалийн хэл боловсруулалтын аргачлалуудыг ашигласнаар олон эх сурвалжийн мэдээллийг нэгтгэн нөхцөл байдлын цогц зураглал гаргах боломж нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч хиймэл оюунд суурилсан системүүд нь буруу ангилал, өгөгдлийн гажуудал болон дайсагнасан халдлагад өртөх эрсдэлтэй тул хүний шинжээчийн хяналттай хослуулан ашиглах шаардлагатай хэвээр байна. Иймээс орчин үеийн батлан хамгаалах кибер хамгаалалт нь хиймэл оюуныг гол тулгуур технологи болгон ашиглаж, илүү ухаалаг, дасан зохицох чадвартай, өндөр хурдтай хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж байна.

Дижитал шилжилт, сүлжээ төвтэй байлдааны үзэл баримтлал, мэдээллийн дэд бүтцийн хамаарал өсөн нэмэгдэж буй өнөө үед кибер орчин нь үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж байна. Батлан хамгаалах салбарын мэдээллийн систем, команд удирдлагын сүлжээ, зэвсгийн удирдлагын платформ, тагнуулын мэдээллийн сангууд нь кибер халдлагын өндөр эрсдэлтэй объект болж байгаа бөгөөд уламжлалт хамгаалалтын арга хэрэгслүүд дангаараа хангалттай үр дүн үзүүлэхгүй болжээ. Ийм нөхцөлд хиймэл оюунд суурилсан кибер хамгаалалтын шийдлүүд нь аюул заналыг урьдчилан илрүүлэх, бодит хугацаанд шинжлэх, халдлагын хэв маягийг тодорхойлох, автомат хариу арга хэмжээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Монгол Улсын батлан хамгаалах салбарын мэдээллийн технологийн хөгжил нэмэгдэхийн хэрээр кибер аюулгүй байдлыг хангах асуудал стратегийн ач холбогдолтой болсон. Иймээс үндэсний онцлог, батлан хамгаалах байгууллагын бүтэц, мэдээллийн урсгал, эрсдэлийн түвшинд нийцсэн хиймэл оюунд суурилсан хамгаалалтын загвар боловсруулах нь онолын болон практик ач холбогдол бүхий судалгааны чиглэл болж байна.

Нэг. Кибер аюулгүй байдлын тухай үндсэн ойлголт, онолын үндэс

Орчин үеийн мэдээллийн нийгэмд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ эрчимтэй өсөн нэмэгдэж, хувь хүн, байгууллага болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаа дижитал орчинд ихээхэн төвлөрөх болсон. Үүний зэрэгцээ мэдээллийн систем, сүлжээ, өгөгдөлд чиглэсэн халдлага, зөвшөөрөлгүй хандалт, мэдээлэл алдагдах зэрэг эрсдэлүүд нэмэгдэж байгаа нь кибер аюулгүй байдлын ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж байна.

“Стандарт, технологийн үндэсний хүрээлэн (NIST)”-гийн кибер аюулгүй байдлын хүрээ (Cybersecurity Framework) нь хамгаалах, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох гэсэн үндсэн функцүүдээр кибер хамгаалалтын үйл ажиллагааг тодорхойлдог (National Institute of Standards and Technology 2024).

Кибер аюулгүй байдал нь компьютерийн систем, сүлжээ, програм хангамж, өгөгдөл болон дижитал дэд бүтцийг халдлага, гэмтэл, зөвшөөрөлгүй нэвтрэлт болон бусад аюул заналаас хамгаалахтай холбоотой бодлого, технологи, үйл ажиллагаа болон хүний хүчин зүйлсийн цогц гэж үзэж болно (National Institute of Standards and Technology 2024).

Кибер аюулгүй байдлын үндсэн зорилго нь мэдээллийн нууцлал (confidentiality), бүрэн бүтэн байдал (integrity), хүртээмжтэй байдал (availability) гэсэн мэдээллийн аюулгүй байдлын суурь гурван зарчмыг хангахад оршино (Stallings 2018). Нууцлал нь зөвхөн эрх бүхий хэрэглэгч мэдээлэлд хандах боломжтой байхыг илэрхийлдэг бол бүрэн бүтэн байдал нь мэдээлэл зөвшөөрөлгүйгээр өөрчлөгдөөгүй, үнэн зөв хэвээр хадгалагдаж буйг баталгаажуулдаг. Харин хүртээмжтэй байдал нь шаардлагатай үед мэдээлэл болон үйлчилгээ хэрэглэгчдэд тасралтгүй хүрч байх нөхцөлийг хангадаг (Whitman, M. E., Mattord, H. J 2022).

Кибер орчинд олон төрлийн аюул занал учирдаг бөгөөд эдгээрийн дотор хортой програм (malware), фишинг халдлага (phishing), үйлчилгээ саатуулах халдлага (Distributed Denial of Service буюу DDoS), ransomware, дотоод хэрэглэгчийн эрсдэл болон нийгмийн инженерчлэлийн халдлагууд түгээмэл тохиолддог. Хортой програм нь системд нэвтрэн өгөгдөл устгах, өөрчлөх, хулгайлах зорилготой байдаг бол фишинг халдлага нь хэрэглэгчийг хуурамч цахим шуудан, вэбсайт эсвэл мессеж ашиглан нууц мэдээллээ өгөхөд хүргэдэг. Сүүлийн жилүүдэд ransomware төрлийн халдлага эрчимтэй нэмэгдэж, байгууллагуудын мэдээллийг шифрлэн барьцаалах замаар их хэмжээний санхүүгийн хохирол учруулж байна (Stallings, W 2024).

Кибер аюулгүй байдлыг хангахад технологийн хамгаалалтын арга хэмжээнээс гадна хүний хүчин зүйл онцгой үүрэгтэй. Судалгаагаар мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн ихээхэн хувь нь хүний алдаа, мэдлэг дутмаг байдал, эсвэл нийгмийн инженерчлэлийн халдлагатай холбоотой байдаг. Иймээс байгууллагууд ажилтнуудаа тогтмол сургах, аюулгүй байдлын соёлыг төлөвшүүлэх, нууц үгийн зохистой бодлого хэрэгжүүлэх, олон хүчин зүйлт баталгаажуулалт (Multi-Factor Authentication) ашиглах шаардлагатай байдаг (Singer, P. W., Friedman, A 2014).

Мөн кибер аюулгүй байдал нь зөвхөн техникийн асуудал бус үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдалтай нягт холбоотой стратегийн ач холбогдолтой салбар болсон. Эрчим хүч, санхүү, харилцаа холбоо, эрүүл мэнд зэрэг чухал дэд бүтцүүд кибер халдлагад өртөх нь улс орны үйл ажиллагаанд ноцтой саад учруулах эрсдэлтэй. Иймээс улс орнууд кибер аюулгүй байдлын бодлого боловсруулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарч байна (Craigen, D., Diakun-Thibault, N., Purse, R 2014).

Кибер аюулгүй байдал нь мэдээлэл, систем, сүлжээ болон дижитал орчныг найдвартай ажиллагааг хангах үндсэн хэрэгсэл бөгөөд өнөөгийн дижитал нийгмийн салшгүй хэсэг юм. Технологийн хөгжилтэй зэрэгцэн кибер заналхийлэл улам нарийсаж байгаа тул байгууллага болон хувь хүмүүс мэдээллийн аюулгүй байдлын мэдлэгээ дээшлүүлж, хамгаалалтын үр дүнтэй арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Кибер аюулгүй байдлын онолын үндэс нь эрсдэлийн удирдлагын онол, системийн онол, мэдээллийн аюулгүй байдлын архитектурын онол, тоглоомын онол болон аюул заналын тагнуулын (Cyber Threat Intelligence) үзэл баримтлалд тулгуурладаг.

Аюул заналын тагнуул (Cyber Threat Intelligence, CTI) нь кибер орчинд үүсэж буй болон үүсэж болзошгүй халдлага, халдагчдын арга барил, зорилго, чадавхыг

системтэйгээр цуглуулах, боловсруулж шинжлэх, тайлбарлах үйл явцыг хэлнэ. Энэ нь зөвхөн техникийн өгөгдөлд тулгуурлахаас гадна стратегийн, тактикийн болон үйл ажиллагааны түвшний мэдээллийг нэгтгэн байгууллагын шийдвэр гаргалтыг дэмжих зорилготой байдаг. Аюул заналын тагнуулын үндсэн зорилго нь болзошгүй аюулыг урьдчилан тодорхойлж, хамгаалалтын арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлэх замаар эрсдэлийг бууруулахад оршино. Ийнхүү аюул заналын тагнуул нь кибер аюулгүй байдлыг реактив бус, харин урьдчилан сэргийлэх, ухаалаг удирдлагад суурилсан түвшинд хүргэх чухал бүрэлдэхүүн хэсэг болдог.

Хүснэгт 1. *Кибер аюулгүй байдлын суурь болдог түгээмэл онолуудын үндсэн ойлголт, гол агуулга болон практикт хэрэглэгдэх ач холбогдол*

Онол	Үндсэн ойлголт	Гол агуулга	Кибер аюулгүй байдал дахь хэрэглээ
Эрсдэлийн удирдлагын онол (Risk Management Theory)	Байгууллагын зорилгод нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлж, бууруулах үйл явц	Эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, үнэлэх, хянах, бууруулах арга хэмжээ боловсруулах	Кибер заналхийлэл, эмзэг байдал, эрсдэлийн түвшинг үнэлэх, хамгаалалтын бодлого боловсруулах, хөрөнгө хамгаалах
Системийн онол (Systems Theory)	Байгууллага нь харилцан хамааралтай дэд системүүдээс бүрдсэн нэгдмэл тогтолцоо гэж үздэг	Оролт (input), боловсруулалт (process), гаралт (output), эргэх холбоо (feedback)-ны уялдаа холбоог судална	Мэдээллийн систем, сүлжээ, хэрэглэгч, техник хэрэгсэл хоорондын хамаарлыг ойлгож аюулгүй байдлыг бүхэлд нь удирдах
Мэдээллийн аюулгүй байдлын архитектурын онол (Information Security Architecture Theory)	Аюулгүй байдлын шаардлагыг системийн бүтэц, архитектурт тусган хэрэгжүүлэх онол	Давхарласан хамгаалалт (Defense in Depth), Zero Trust, аюулгүй байдлын загварчлал, архитектурын удирдлага	Байгууллагын мэдээллийн системийн хамгаалалтын бүтэц төлөвлөх, нэвтрэх эрхийн хяналт, өгөгдөл хамгаалах
Тоглоомын онол (Game Theory)	Өрсөлдөгч талуудын шийдвэр гаргалтыг стратегийн харилцан үйлчлэлээр тайлбарладаг онол	Ашиг, зардал, эрсдэлийг тооцон хамгийн оновчтой стратегийг тодорхойлох	Халдагч ба хамгаалагчийн үйл ажиллагааг загварчлах, кибер хамгаалалтын стратеги боловсруулах

Мэдээллийн баталгаажуулалтын онол (Information Assurance Theory)	Мэдээллийн найдвартай байдал, хүртээмж, бүрэн бүтэн байдлыг хангах онол	Нууцлал (Confidentiality), Бүрэн бүтэн байдал (Integrity), Хүртээмжтэй байдал (Availability)-ын зарчим	Батлан хамгаалах болон төрийн байгууллагын мэдээллийн хамгаалалтын бодлого боловсруулах
Байгууллагын тогтвортой байдлын онол (Organizational Resilience Theory)	Байгууллага эрсдэл, халдлага, доголдлын үед үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадвар	Эрсдэлд дасан зохицох, сэргээн босгох, тасралтгүй ажиллагааг хангах	Кибер халдлагын дараах сэргэлт, бизнесийн болон үйл ажиллагааны тасралтгүй байдал
Нийгэм-техникийн системийн онол (Socio-Technical Systems Theory)	Технологи болон хүний хүчин зүйл харилцан нөлөөлдөг гэж үздэг	Техник, байгууллага, хүний зан төлөвийн уялдаа холбоо	Фишинг халдлага, дотоод аюул занал, хэрэглэгчийн аюулгүй байдлын зан төлөвийг судлах
Гүн хамгаалалтын онол (Defense in Depth Theory)	Нэг хамгаалалт алдагдсан ч бусад хамгаалалт үргэлжлэн ажиллах олон давхар хамгаалалтын зарчим	Сүлжээ, систем, өгөгдөл, хэрэглэгчийн түвшний олон шатлалт хамгаалалт	Батлан хамгаалах байгууллагын кибер хамгаалалтын архитектурын үндсэн зарчим болдог

Дээрх хүснэгтэд дурьдсан онолуудаас батлан хамгаалах байгууллагын кибер аюулгүй байдлын судалгаанд хэд хэдэн онолын хандлагыг өргөн ашигладаг бөгөөд эдгээр нь байгууллагын мэдээллийн хөрөнгө, дижитал дэд бүтэц, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хамгаалах асуудлыг олон талаас нь тайлбарлах боломжийг олгодог. Эдгээр онолуудаас эрсдэлийн удирдлагын онол, системийн онол, мэдээллийн аюулгүй байдлын архитектурын онол, тоглоомын онол болон байгууллагын тогтвортой байдлын онол нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг онолуудын тоонд ордог.

Юуны өмнө эрсдэлийн удирдлагын онол нь кибер аюулгүй байдлын судалгааны үндсэн онолын суурь болдог. Энэхүү онолын дагуу байгууллагын мэдээллийн системд учирч болзошгүй аюул занал, эмзэг байдал болон тэдгээрээс үүсэх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн, зохих хамгаалалтын арга хэмжээг төлөвлөх боломж бүрддэг. Батлан хамгаалах байгууллагын хувьд кибер халдлага нь зөвхөн мэдээллийн алдагдал үүсгэхээс гадна үндэсний аюулгүй байдал, цэргийн ажиллагааны үр дүнд нөлөөлөх өндөр эрсдэлтэй байдаг тул эрсдэлийн удирдлагын онол нь кибер хамгаалалтын бодлого боловсруулах, нөөцийн оновчтой хуваарилалт хийх, хамгаалалтын тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг.

Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд эрсдэлийн удирдлагын онолын үүднээс хиймэл оюуныг ашиглах нь аюул заналыг

тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээ төлөвлөх болон хяналт тавих бүх үе шатыг илүү үр ашигтай болгох боломжтой. Эрсдэлийн удирдлагын уламжлалт загваруудтай уялдуулан хиймэл оюунд суурилсан системүүд нь сүлжээний урсгал, системийн лог, эмзэг байдлын мэдээлэл болон аюул заналын тагнуулын өгөгдлийг нэгтгэн боловсруулж, эрсдэлийн магадлал болон нөлөөллийг илүү нарийвчлалтай тооцоолдог (National Institute of Standards and Technology 2012). Мөн машин сургалтын алгоритмууд нь динамик орчинд шинэ төрлийн халдлагын хэв шинжийг илрүүлж, эрсдэлийн түвшинг бодит цаг хугацаанд шинэчилснээр шийдвэр гаргалтын чанарыг сайжруулдаг (Sarker, I. H., Kayes, A. S. M., Badsha, S., Alqahtani, H., Watters, P., Ng, A 2020). Үүний зэрэгцээ хиймэл оюун нь автоматжуулсан эрсдэлийн үнэлгээ болон SOAR-т суурилсан хариу арга хэмжээний системтэй уялдан ажилласнаар хамгаалалтын үйл ажиллагааны хурд, үр нөлөөг нэмэгдүүлдэг. Иймээс хиймэл оюуныг эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нэгтгэх нь батлан хамгаалах салбарын кибер хамгаалалтыг илүү дасан зохицох чадвартай, өгөгдөлд суурилсан, стратегийн түвшний шийдвэр гаргалтыг дэмжих чухал арга зам болж байна.

Хоёрдугаарт, системийн онол нь батлан хамгаалах байгууллагыг харилцан хамааралтай олон дэд системээс бүрдсэн нэгдмэл тогтолцоо гэж үздэг. Орчин үеийн батлан хамгаалах байгууллагын үйл ажиллагаа нь мэдээллийн систем, холбооны сүлжээ, хүний нөөц, команд удирдлагын бүтэц болон техникийн дэд бүтцийн нягт уялдаанд тулгуурладаг. Иймээс системийн онол нь кибер аюулгүй байдлын асуудлыг зөвхөн технологийн өнцгөөс бус байгууллагын бүхэл бүтэн үйл ажиллагаатай холбон судлах боломжийг олгодог. Нэг дэд системд гарсан доголдол нь бусад системийн ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг ойлгох нь кибер эрсдэлийг цогцоор нь үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг системийн онолын үүднээс авч үзвэл хиймэл оюун нь хоорондоо уялдаа холбоотой олон дэд системээс бүрдэх цогц хамгаалалтын экосистемийг оновчтой удирдах хэрэгсэл болж ашиглагдана. Системийн онолын дагуу кибер орчин нь өгөгдөл цуглуулах, боловсруулалт хийх, шийдвэр гаргалт болон хариу үйлдэл зэрэг харилцан хамааралтай бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэх тул хиймэл оюун нь эдгээрийн хооронд мэдээллийн урсгалыг нэгтгэн, бодит цагийн нөхцөл байдлын цогц дүр зургийг (situational awareness) бүрдүүлэхэд чухал үүрэгтэй (Bertalanffy, L. von 1968). Мөн машин сургалт нь системийн доторх хэвийн ба хэвийн бус зан төлөвийн уялдаа холбоог илрүүлснээр гажуудлыг эрт таних, системийн тогтвортой байдлыг хадгалах боломжийг нэмэгдүүлдэг (Sarker, I. H., Kayes, A. S. M., Badsha, S., Alqahtani, H., Watters, P., Ng, A 2020). Үүнээс гадна хиймэл оюун нь дэд системүүдийн хоорондын хариу үйлдлийг автоматжуулж, SOAR болон SIEM платформуудтай уялдан ажилласнаар бүхэл системийн өөрөө зохицох болон дасан зохицох чадварыг сайжруулдаг. Иймээс системийн онолын хүрээнд хиймэл оюуныг ашиглах нь батлан хамгаалах салбарын кибер хамгаалалтыг цогц, уялдаа холбоотой, тасралтгүй сайжрах чадвартай систем болгон хөгжүүлэх үндсэн арга зам юм.

Гуравдугаарт, мэдээллийн аюулгүй байдлын архитектурын онол нь байгууллагын мэдээллийн системийн хамгаалалтын бүтэц, зохион байгуулалт болон хамгаалалтын давхаргуудыг төлөвлөхөд чиглэдэг. Энэхүү онолын хүрээнд

хамгаалалтын олон давхаргат аргачлал (Defense in Depth), Тэг итгэлцлийн архитектур (Zero Trust Architecture) зэрэг орчин үеийн хамгаалалтын загваруудыг ашигладаг. Батлан хамгаалах байгууллагын хувьд мэдээллийн аюулгүй байдлын архитектур нь нууц мэдээллийг хамгаалах, хэрэглэгчийн эрхийн удирдлагыг хэрэгжүүлэх, системийн найдвартай ажиллагааг хангах үндсэн механизм болж өгдөг. Тиймээс энэхүү онол нь байгууллагын кибер хамгаалалтын техникийн суурийг бүрдүүлдэг гэж үздэг.

Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг мэдээллийн аюулгүй байдлын архитектурын онолын үүднээс авч үзвэл хиймэл оюун нь давхаргат хамгаалалтын бүтэц (defense-in-depth)-ийг илүү ухаалаг, дасан зохицох чадвартай болгон хөгжүүлэх үндсэн бүрэлдэхүүн болж ашиглагдана. Архитектурын хандлагад тулгуурлан хиймэл оюун нь өгөгдөл цуглуулах, боловсруулах, хадгалах болон хамгаалах давхаргуудын хоорондын мэдээллийн урсгалыг уялдуулж, аюулгүй байдлын хяналтын цэг бүрт бодит цагийн дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлдэг (McGraw 2006). Мөн машин сургалтын аргууд нь сүлжээний зан төлөв болон системийн харилцан үйлчлэлд суурилан аюулын хэв шинжийг тодорхойлж, архитектурын түвшинд сул талуудыг эрт илрүүлэхэд тусалдаг (Sarker, I. H., Kayes, A. S. M., Badsha, S., Alqahtani, H., Watters, P., Ng, A 2020). Үүнээс гадна хиймэл оюун нь SIEM болон SOAR зэрэг архитектурын бүрэлдэхүүн системүүдтэй уялдан ажилласнаар автомат хяналт, хариу арга хэмжээний давхаргыг бий болгож, хамгаалалтын үр ашгийг нэмэгдүүлдэг. Иймээс мэдээллийн аюулгүй байдлын архитектурын хүрээнд хиймэл оюуныг нэгтгэх нь батлан хамгаалах салбарын кибер хамгаалалтыг илүү бүтэцлэгдсэн, давхар хамгаалалттай, өндөр үр ашигтай систем болгон хөгжүүлэх чухал арга зам юм.

Дөрөвдүгээрт, тоглоомын онол нь кибер халдагч болон хамгаалагч талуудын стратегийн харилцан үйлчлэлийг судлахад ашиглагддаг. Кибер орчинд халдагч болон хамгаалагч аль аль нь өөрсдийн зорилго, боломж, нөөцөд тулгуурлан шийдвэр гаргадаг бөгөөд нэг талын үйлдэл нөгөө талын шийдвэрт нөлөөлдөг онцлогтой. Иймээс тоглоомын онол нь халдагчийн боломжит үйл ажиллагааг урьдчилан таамаглах, хамгаалалтын оновчтой стратегийг тодорхойлох, нөөцөө үр ашигтай хуваарилах зэрэг асуудлыг судлахад өргөн хэрэглэгддэг.

Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг тоглоомын онолын үүднээс авч үзвэл хиймэл оюун нь хамгаалагч болон халдагч талуудын стратегийн харилцан үйлчлэлийг загварчлах, оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих хүчирхэг хэрэгсэл болж ашиглагдана. Тоглоомын онолын хүрээнд кибер орчин нь олон оролцогчтой, өрсөлдөөнт нөхцөл тул хиймэл оюунд суурилсан алгоритмууд нь халдагчийн боломжит стратегийг урьдчилан таамаглаж, хамгаалалтын хамгийн оновчтой хариу үйлдлийг тодорхойлох боломжийг бүрдүүлдэг (Pita, J., Jain, M., Ordóñez, F., Tambe, M., et al 2010). Мөн reinforcement learning зэрэг машин сургалтын арга нь динамик орчинд давтагдсан харилцан үйлчлэлээс суралцаж, Nash equilibrium-д ойр шийдвэр гаргалтыг автоматжуулахад ашиглагддаг (Shoham, Y., Leyton-Brown, K 2009). Үүнээс гадна хиймэл оюун нь олон хувилбарт тоглоомын симуляци үүсгэж, кибер халдлагын боломжит сценарийг урьдчилан үнэлснээр стратегийн эрсдэлийг бууруулахад тусалдаг. Иймээс тоглоомын онолын үүднээс хиймэл оюуныг ашиглах нь батлан хамгаалах салбарын кибер хамгаалалтыг илүү

стратеги суурьтай, дасан зохицох чадвартай, оновчтой шийдвэр гаргалт бүхий систем болгон хөгжүүлэх чухал арга зам юм.

Түүнчлэн байгууллагын тогтвортой байдлын онол нь кибер халдлага, техникийн саатал болон бусад эрсдэлийн үед байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадварыг тайлбарладаг. Батлан хамгаалах байгууллагын хувьд үйл ажиллагааны тасралтгүй байдал нь үндэсний аюулгүй байдлыг хангах гол нөхцөлүүдийн нэг бөгөөд кибер халдлагын дараах сэргэлт, нөөцлөлт, гамшгийн үеийн сэргээн босголтын төлөвлөгөө боловсруулахад энэхүү онол чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг байгууллагын тогтвортой байдлын онолын үүднээс авч үзвэл хиймэл оюун нь тасралтгүй ажиллагаа, дасан зохицох чадвар болон алдаа тэсвэрлэх чадамжийг хангахад чухал үүрэгтэй. Тогтвортой байдлын онолд тулгуурлан байгууллага нь гадны болон дотоод шок, тухайлбал кибер халдлага, системийн доголдол зэрэгт өртсөн ч үндсэн үйл ажиллагаагаа хадгалах чадвартай байх ёстой бөгөөд хиймэл оюун нь ийм нөхцөлд эрсдэлийг эрт илрүүлж, системийн сул талыг бодит цагт тодорхойлох боломжийг бүрдүүлдэг (Linkov 2013).

Мөн машин сургалтын алгоритмууд нь хэвийн үйл ажиллагааны суурь загварыг тодорхойлж, гажуудлыг илрүүлэх замаар системийн сэргээгдэх чадварыг (recovery capability) нэмэгдүүлдэг. Үүнээс гадна хиймэл оюун нь автоматжуулсан хариу арга хэмжээ болон SOAR системүүдтэй уялдан ажилласнаар халдлагын үед шийдвэр гаргалтын хугацааг бууруулж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад тусалдаг. Иймээс байгууллагын тогтвортой байдлын онолын хүрээнд хиймэл оюуныг ашиглах нь батлан хамгаалах салбарын кибер хамгаалалтыг илүү уян хатан, сэргээгдэх чадвартай, тасралтгүй ажиллагаатай систем болгон хөгжүүлэх үндсэн арга зам юм.

Иймээс батлан хамгаалах байгууллагын кибер аюулгүй байдлын судалгаанд эдгээр онолуудыг дангаар нь бус харилцан уялдуулан ашиглах нь илүү үр дүнтэй байдаг. Эрсдэлийн удирдлагын онол нь эрсдэлийг тодорхойлж үнэлэх үндэс болдог бол системийн онол нь байгууллагыг бүхэлд нь ойлгох боломжийг бүрдүүлдэг.

Харин мэдээллийн аюулгүй байдлын архитектурын онол нь хамгаалалтын техникийн шийдлийг тодорхойлж, тоглоомын онол нь халдагч болон хамгаалагчийн стратегийн харилцааг тайлбарладаг. Үүний зэрэгцээ байгууллагын тогтвортой байдлын онол нь аливаа кибер эрсдэл үүссэн нөхцөлд байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хадгалах арга замыг тодорхойлдог.

Иймээс эдгээр онолууд нь батлан хамгаалах байгууллагын кибер аюулгүй байдлын онолын үндсийг бүрдүүлж, мэдээллийн нууцлал, системийн хамгаалалт болон үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах асуудлыг цогц байдлаар судлах боломжийг олгодог.

Орчин үеийн халдлагууд улам бүр автоматжиж, олон үе шаттай болж байгаа тул зөвхөн дүрэмд суурилсан хамгаалалт хангалтгүй болсон. Энэ нь хиймэл оюунд суурилсан хамгаалалтын системийг хөгжүүлэх онолын үндэслэлийг бүрдүүлж байна.

Хоёр. Хиймэл оюунд суурилан кибер аюулгүй байдлыг хамгаалах нь

Хиймэл оюун нь машин сургалт (Machine Learning), гүн сургалт (Deep Learning), мэдрэлийн сүлжээ (Neural Network), байгалийн хэл боловсруулах технологи (Natural Language Processing) зэрэг арга технологид тулгуурлан өгөгдлөөс суралцах боломжийг олгодог (Russell, S., Norvig, P 2021).

Кибер хамгаалалтын салбарт хиймэл оюуныг дараах чиглэлээр өргөн ашиглаж байна. Үүнд:

- Халдлагын хэв шинж илрүүлэх;
- Сүлжээний хэвийн бус үйл ажиллагааг тодорхойлох;
- Хортой кодыг ангилах;
- Эрсдэлийн урьдчилсан таамаглал хийх;
- Автомат хариу арга хэмжээ боловсруулах;
- Тагнуулын мэдээлэл боловсруулах зэрэг юм.

Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг хангах хүрээнд хиймэл оюун нь халдлагын хэв шинжийг илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хиймэл оюунд суурилсан системүүд нь сүлжээний урсгал, хэрэглэгчийн үйл ажиллагаа, төхөөрөмжүүдийн харилцаа холбоо болон өмнөх халдлагын өгөгдлийг боловсруулж, кибер халдлагын нийтлэг болон нарийн төвөгтэй хэв маягийг тодорхойлдог (Buczak, A. L., Guven, E 2016).

Машин сургалтын алгоритмууд нь их хэмжээний өгөгдлөөс давтагдах шинж тэмдэг, зан төлөвийн өөрчлөлт болон сэжигтэй үйл ажиллагааг илрүүлснээр халдлагын эхний үе шатыг таних боломжийг олгодог. Батлан хамгаалах байгууллагууд энэхүү технологийг ашиглан дэвшилтэт тогтвортой заналхийлэл (APT), тархмал үйлчилгээ саатуулах халдлага (DDoS) болон зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг илүү үр дүнтэй илрүүлдэг. Ялангуяа гүн сургалтын загварууд нь олон эх сурвалжаас ирсэн өгөгдлийн уялдаа холбоог шинжилж, хүний нүдэнд шууд харагдахгүй хэв шинжийг тодорхойлох чадвартай байдаг (Shone, N., Ngoc, T. N., Phai, V. D., Shi, Q 2018). Энэ нь халдлагыг эрт үед нь илрүүлж, хамгаалалтын хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Гэсэн хэдий ч хиймэл оюуны системийн үр ашиг нь сургалтын өгөгдлийн чанар, худал эерэг дохиоллын түвшин болон шинэ төрлийн халдлагыг таних чадвараас ихээхэн хамаардаг. Иймээс хиймэл оюунд суурилсан халдлагын хэв шинж илрүүлэх аргыг хүний шинжээчдийн дүн шинжилгээтэй хослуулан ашиглах нь батлан хамгаалах салбарын кибер хамгаалалтыг бэхжүүлэх үр дүнтэй арга зам болдог.

